



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/09/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2021 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Э.ДАВААНЯМ ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжнэ хороолол, Жинет баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2022.01.24

№

121

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Боловсролын ерөнхий газрын дарга" гэсэн агуулгатай заалт оруулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 91 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 139 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 96.1 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

0702000291

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,522,558.40	2,452,175.80
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	40,288,646.70	12,961,086.80
	Нийт хөрөнгийн дүн	43,811,205.10	15,413,262.60
	Нийт өр төлбөрийн дүн	233,893.10	111,422.30
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	43,577,312.10	15,301,840.30
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	43,811,205.10	15,413,262.60
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	29,642,737.00	18,175,380.50
	Үйл ажиллагааны зардлын дүн	24,408,765.60	15,280,962.90
	Үйл ажиллагааны үр дүн	5,233,971.50	2,894,417.60
	Үйл ажиллагааны бус үр дүн	1,092,114.70	30,267,865.50
	Үйл ажиллагааны нийт үр дүн	4,141,856.80	-27,373,448.00
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,602,928.50	43,577,312.10
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бүүралт	-68,364.50	
	Үндсэн хөрөнгийн өсөлт бүүралт	27,980.00	
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-902,023.80
	Өмчид гарсан өөрчлөлт	1,872,911.30	
	Тайлант оны үр дүн	4,141,856.80	-27,373,448.00
	Эцсийн үлдэгдэл	43,577,312.10	15,301,840.30
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	22,168,523.00	15,692,148.90
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	20,902,006.60	14,199,531.40
	Үйл ажиллагааны ЦМГ	1,266,516.30	1,492,617.50
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-1,105,483.60	-1,235,200.40
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-296,654.00	-340,000.00
	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	296,654.00	340,000.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-135,621.30	-82,582.90
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	936,429.50	800,808.10
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	800,808.10	718,225.20

Гурав. Аудитын илрүүлэлт:

3. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 20 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 1 төрийн сан, 3 өрхийн эрүүл мэндийн төв, 2 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нийт 29 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн.

Нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн харьяа нэгж, байгууллагуудад 2,158.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,178.2 сая төгрөгийн алдааг залруулж, 53.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 963.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж 10 заалт

бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Мөн 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 1 зөрчлийн хувьд Үндэсний аудитын газарт шалгуулахаар хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,178.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- ✓ Санхүүгийн байдлын тайланд авлагыг 13.5 сая төгрөгөөр, борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгийг 34.8 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийг 841.5 сая төгрөгөөр, өглөгийг 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
- ✓ Үр дүнгийн тайланд орлогыг 2.3 сая төгрөгөөр, зардлыг 2.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
- ✓ Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 364.0 сая төгрөгөөр, зардлыг 21.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 53.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 заалт бүхий 53.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлжээ. Мөн 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

- ✓ Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс хөрөнгийн орлогыг 197.8 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 27.4 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийг 3.1 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 17.3 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 100.0 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 12.6 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төсөвт байгууллагуудын батлагдсан төсвийн санхүүжилтийг 31.1 сая төгрөгөөр илүү, 15.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" гэсэн заалт, Есөнбулаг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 07 дугаар тогтоол"-ыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ "Оюуны түлхүүр" бага сургууль нь татан буугдсан байхад нэгтгэсэн тайланд 2.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 3.4 сая төгрөгийн засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэлтэй нэгтгэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", 20.2.9-т "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;"; заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс түүвэрчилж үзэхэд Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 22.7 сая төгрөгийн 9 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд мэдээлэх шаардлагатай мэдээллийг мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Есөнбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	3	1280.6			3	1280.6	3	1280.6				
Есөнбулаг сумын ЗДТГ	7	204.7			7	204.7	7	204.7				

Есөнбулаг сумын ИТХ	5	53.8	1	3.1	5	50.7	5	53.8				
Есөнбулаг сумын ОНХС	0											
Есөнбулаг сумын Хоршоо хөгжүүлэх сан	4	14.881			4	14.881	4	14.881				
Есөнбулаг сумын БХНС сан	1	0.75	1	0.75			1	0.75				
Марал-Алтай ӨЭМТ	2	106.6			2	106.6	2	106.6				
Жаргалан-Алтай ӨЭМТ	1	40.4	1	40.4	-	-	1	40.4				
Энх-Алтай ӨЭМТ	2	47.3			2	47.3	2	47.3	-			
"Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ	2	847.5	1	37.4	1	810.1	2	847.5				
Дүн	25	2458.8	3	41.3	21	2417.6	23	2458.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Есөнбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	2	52.6	0	0	2	52.6						
Есөнбулаг сумын ЗДТГ	16	215.1	7	28.8	8	186.3			1	3		
Есөнбулаг сумын ИТХ	16	97.6	7	8.8	9	89.6						
Есөнбулаг сумын ОНХС	8	462.8			7	462.8			1			
Есөнбулаг сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	27.04	1	6.4	1	20.6	1					
Есөнбулаг сумын БХНС сан	1	0.25	1	0.25								
Марал-Алтай ӨЭМТ	5	2.1	2	1	1	1.1	1	-	1	1		
Жаргалан-Алтай ӨЭМТ	3	0.8	-	-	1	0.8	2					
Энх-Алтай ӨЭМТ	1	0.5			1	0.5						


"Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ	5	11.8	2	2.4	3	9.4	-	-	2	2		
"Алтай хотын цогц үйлчилгээний газар" УТҮГ	7	99.7	3	5.5	3	94.2						
Дүн	67	970.3	23	53.1	36	917.9	4	0	5	6	1	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Есөнбулаг сумын ЗДТГ	1						1	
Марал-Алтай ӨЭМТ	1				1			
Энх-Алтай ӨЭМТ	1						1	
Дүн	3				1		2	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Есөнбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	358.4	-	-	1	358.4		
Есөнбулаг сумын ЗДТГ	4	53.6	-	-	3	53.6	1	
Есөнбулаг сумын ИТХ	2	9.1	-	-	2	9.1		
Марал-Алтай ӨЭМТ	2				1		1	
Жаргалан-Алтай ӨЭМТ	1						1	
Энх-Алтай ӨЭМТ	2				1		1	
"Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ	3		-	-	2		1	
"Алтай хотын цогц үйлчилгээний газар" УТҮГ					1	35.3		
Дүн	12	421.1	0	0	9	456.4	5	
Нийт дүн	15	421.1	0	0	10	456.4	7	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
	А	Б	
	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		



	Төсвийн захирагчийн ангилал		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1	-	-	1		-	-
2	ТШЗ	5	5			2	3		
3	ОНТС	3		3					
4	ААТҮГ	2	2			2			
	НИЙТ	11	8	3	-	5	3	-	-